13

# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр Дугаар 11 Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 125,000,000 /Нэг зуун хорин таван сая/ төгрөгийн үнэтэй "TOYOTA Land Cruiser-150 prado" маркын автомашиныг нэгдүгээр хавсралтаар, 6,569,200 /Зургаан сая таван зуун жаран есөн мянга хоёр зуу/ төгрөгийн үнэтэй машин тоног төхөөрөмжийг хоёрдугаар хавсралтаар үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах,

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган,''Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем''-д бүртгэх,

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12-ний өдрийн 11 тогтоолын нэгдүгээр хавсралт

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ОРЛОГОД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 1. Авто, тээврийн хэрэгсэл

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэр-лэсэн он | Ашиглалтад орсон огноо | Тээврийн хэрэгслийн | | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сери | дугаар | | | арлын дугаар | моторын эзлэхүүн | | | | | |
| 1 | Суудал | Тоёота ланд круйзер-150 прадо | ДУН | 00-22 | 2019 | 2020-06-22 | JTEBX9FJ60K325132 | B2694 | 150 | 125,000,000.00 | - | - | Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан |
| ДҮН | | | | | | | | | | 125,000,000.00 | - | - | |

15

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12-ний өдрийн 11 тогтоолын хоёрдугаар хавсралт

2. Машин тоног төхөөрөмж

| Д/д | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Тоо хэмжээ | Дүн | Хөрөнгө олж авах эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Компьютер (иж бүрэн) | ш | 1,749,800 | 3 | 5,249,400 | Төлөвлөгөө давсан орлогоор |
| 2 | Принтер (олон үйлдэлт) | ш | 849,900 | 1 | 849,900 | Төсвийн хөрөнгөөр |
| 3 | Кофе чанагч | ш | 89,900 | 1 | 89,900 | Төсвийн хөрөнгөөр |
| 4 | Угаалгын машин (11кг) | ш | 380,000 | 1 | 380,000 | Төсвийн хөрөнгөөр |
| Дүн | | | | 1 | 6,569,200 | |